

Энэхүү ТМТ нь 2015 оны 10 сарын 6-ны өдрийн Англи хувилбарын орчуулга болно.



ASIAN DEVELOPMENT BANK

**Монгол Улс: Хөвсгөл нуурын байгалийн цогцолбор газарт иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх нэгдсэн төсөл**

Төслийн нэр	Хөвсгөл нуурын байгалийн цогцолбор газарт иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх нэгдсэн төсөл	
Төслийн дугаар	48216-001	
Улс орон	Монгол Улс	
Төслийн статус	Санал болгож буй	
Төслийн төрөл / Тусламжийн хэлбэр	Буцалтгүй тусламж	
Хөрөнгийн эх үүсвэр / Хэмжээ	<b>Буцалтгүй тусламж: Хөвсгөл нуурын байгалийн цогцолбор газарт иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх</b>	
	Ядуурлыг бууруулах Японы сан	3.0 сая ам.доллар
Стратегийн зорилт	Байгальд ээлтэй тогтвортой хөгжил Эдийн засгийн хүртээмжтэй өсөлт	
Хөдөлгөгч хүчин зүйл	Засаглал ба чадавх хөгжүүлэх Түншлэлүүд	
Салбар / Дэд салбар	<b>Хөдөө аж ахуй ба байгалийн баялаг</b> – Хөдөө аж ахуй, байгалийн баялаг ба хөдөөгийн хөгжил	
Жэндрийн тэгш байдал ба оролцоо	Жэндрийн тэгш байдлын үзэл баримтлалыг үр өгөөжтэй нэвтрүүлэх	
Агуулга	Хөвсгөл аймаг дахь Хөвсгөл нуурын байгалийн цогцолбор газар (ХНБЦГ)-т аялал жуулчлалын салбар хурдацтай хэдий ч хяналт муутай хөгжиж байгаа ба орон нутгийн ард иргэд харьцангуй орлого багатай, аялал жуулчлалын хөгжлөөс үр ашиг бага хүртдэг бөгөөд байгалийн баялагт түшиглэн амьжиргаагаа залгуулах төдий амьдарч байна. Санал болгож буй буцалтгүй тусламжийн хувьд, хамгаалалтын газрын захиргаа болон бусад гол оролцогч талуудтай хамтран, аялал жуулчлал, амьжиргааны бусад эх үүсвэрийг тогтвортой хөгжүүлэх чадавхийг бэхжүүлэх замаар ард иргэдийн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэнэ. Төслийн төлөвлөлтөд амьжиргаа, аялал жуулчлал, хог хаягдлын менежмент, газар ашиглалтын	

---

	<p>төлөвлөлтийг нэгтгэсэн аргачлалыг тусгах бөгөөд Монгол Улсын бусад тусгай хамгаалалттай газруудын хувьд загвар болгох зорилготой.</p>
<p>Төслийн үндэслэл ба Улс/Бүсийн стратегитай уялдсан байдал</p>	<p>ХНБЦГ-ыг 1992 онд байгуулсан бөгөөд дэлхийн цэнгэг усны хамгийн чухал эх үүсвэрийн нэг болох Хөвсгөл нуурыг тойрон хүрээлэх 1.2 сая га ой мод, уул толгодыг хамардаг. Хөвсгөл нуур нь Монгол Улсын хамгийн том цэнгэг нуур бөгөөд тус улсын цэнгэг усны нөөцийн 70 хувь, дэлхийн цэнгэг усны нөөцийн 1 хувийг агуулна. Хөвсгөл нуураас эх авсан Монголын хамгийн том гол болох Сэлэнгэ мөрөн нь ОХУ-ын Байгаль нууранд цутгадаг тул Хөвсгөл нуурын хувьд хил дамнасан ач холбогдолтой юм.</p> <p>ХНБЦГ нь Монгол Улс дахь хамгийн олон жуулчдыг татсан аялал жуулчлалын газар болж байгаа бөгөөд тэнд очих жуулчдын тоо, аялал жуулчлалын байгууламжууд хурдацтай олширч байна. 2010-2014 оны хооронд, ХНБЦГ-т нэг жилд зочилсон жуулчдын тоо 11,000-аас 60,000 болж өссөн нь зам харгуй сайжирч, виз олгох журам хялбарчлагдсантай холбоотой. Цаашдын өсөлтийн чиг хандлагын талаар таамаг одоогоор байхгүй хэдий ч, Хөвсгөл аймаг болон ХНБЦГ-г аялал жуулчлал, түүний дэд бүтцийн тулгуур бүс хэмээн тодорхойлсон бөгөөд өсөлт үргэлжилнэ гэсэн хүлээлттэй байна.</p> <p>Ард иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, биологийн олон янз байдлын хамгаалалд сөргөөр нөлөөлөхгүй, аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэхэд томоохон сорилтууд тулгарч байна, үүнд: (i) аялал жуулчлалтай холбоотой шинэ бүтээн байгуулалт, нэгдсэн төлөвлөлтгүй хийгдэж байна – ХНБЦГ-ын захиргаа, нутгийн иргэд, аялал жуулчлалын компаниуд (ХНБЦГ-ын гол оролцогч талууд)-ын уялдаа холбоог хангах эрх зүйн орчин, хамтын алсын хараа, зорилго, аялал жуулчлалын үйл ажиллагааны дүрэм журам дутагдаж байна; (ii) ХНБЦГ дахь зарим сумд улсдаа хамгийн ядууд ордог боловч, ихэнх нь аялал жуулчлалаас улбаатай үр ашгийг хүртэх чадамж болон нөөц бололцоо хязгаарлагдмал байна; (iii) жуулчны отгуудын шингэн болон хуурай хог хаягдал хяналтгүй байгаа бөгөөд нуурын усны чанарт нөлөөлж байна; (iv) цогцолбор газрын оршин суугчдын нилээд хувийн орлогын гол эх үүсвэр нь мал аж ахуй хэвээр байх төлөвтэй байгаа боловч бэлчээрийн даац хэтэрснээс үр ашиг нь буурч байна.</p> <p>Засгийн газар, хандивлагчдын санаачилгуудаар эдгээр асуудлын заримыг шийдвэрлэж байгаа хэдий ч ХНБЦГ-ын</p>

---

оршин суугчдыг түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлж, хог хаягдлын менежментийг сайжруулах зайлшгүй шаардлагатай болсныг Засгийн газар, ард иргэд, аялал жуулчлалын компаниуд хүлээн зөвшөөрч байгаа юм.

Үндэсний түвшинд авч үзвэл, тусгай хамгаалалттай газар нутгуудад ард иргэдийн амьжиргаа, аялал жуулчлал, хог хаягдлын менежмент, биологийн олон янз байдлын хамгааллын зорилтуудыг тэнцвэржүүлэх нэгдмэл бодлого хурцаар шаардагдаж байна. Аялал жуулчлалыг хөгжүүлэх Засгийн газрын бодлого нь Монгол Улсын онгон зэрлэг, хосгүй үзэсгэлэнт байгалийн нөөц, нийт газар нутгийн 18 хувийг хамарсан тусгай хамгаалалттай газруудад голлон түшиглэсэн. Эдгээр газар нутаг ихэвчлэн дэд бүтцийн хөгжил дорой, ядуу бүс нутгуудад байрласан тул экологийн үнэ цэнийг хадгалж хамгаалах, оршин суугчдад үр ашиг хүртээх, аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэхэд ихээхэн хүндрэл бэрхшээл тулгардаг. Ийм шаардлагуудыг хангаж чадсан загвар ховор бөгөөд тус төсөл нь Монгол Улсын хамгаалалттай газар нутаг дахь ард иргэдийн амьжиргаа, аялал жуулчлал, хог хаягдлын менежментийн асуудлуудыг нэгдсэн байдлаар авч үзэх анхны төсөл болно. ХНБЦГ-т оролцооны шинэ механизмуудыг нэвтрүүлэх бөгөөд үүнд аялал жуулчлал, хог хаягдлын нэгдсэн менежментийн арга замууд, амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн ард иргэдийн өөрсдөө удирдах эргэлтийн сан зэрэг үйл ажиллагаа багтана.

Үр нөлөө (i) Хөвсгөл аймгийн 5 сумд нэг хүнд ногдох орлогын хэмжээ өснө;

Үр дагавар (ii) ХНБЦГ-ын байгалийн баялгийн менежмент сайжирна  
ХНБЦГ-ын 5 сумд оршин суугчдын амьжиргаа тогтвортой аялал жуулчлалын хөгжилд тулгуурлан сайжирна

Үр дүн Хатгал, Ханх тосгонд оршин суугчдын эрхэлдэг аялал жуулчлалын үйлчилгээ сайжирна

Хөвсгөл нуур орчмын хог хаягдлын менежмент сайжирна

ХНБЦГ, орчны бүсэд мал аж ахуйг тогтвортой хөгжүүлэх болон бэлчээрийн менежментийн чадавхи бэхжинэ

Газарзүйн байрлал

**Хамгааллын бодлогын ангилал**

Байгаль орчин С

Албадан нүүлгэн шилжүүлэлт С

Уугуул иргэд С

## Байгаль орчин, нийгмийн асуудлын товчоон

Байгаль орчин	Байгаль орчны үнэлгээ, хяналтын төлөвлөгөө (БОҮНХТ)-г боловсруулсан бөгөөд түүнд төслийн хүрээнд хийгдэх бүхий л арга хэмжээнд хамаарах байгаль орчинд нөлөөлөх байдлын анхан шатны үнэлгээ, менежмент болон тайлагнах журмыг багтаасан байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-г боловсруулсан.
Албадан нүүлгэн шилжүүлэлт	Төслийн хүрээнд албадан нүүлгэн шилжүүлэлт болон газар чөлөөлөлт хийгдэхгүй.
Уугуул иргэд	Монгол Улсын нийгмийн эмзэг бүлэгт тооцогдох, үндэстний цөөнх болсон Цаатан ястнууд зөвхөн Хөвсгөл аймагт оршин сууж, амьжиргаагаа залгуулдаг. Тэд ХНБЦГ-аас баруун зүгт 50 км-ийн зайд амьдарч байна. Зарим өрхийн гишүүд Хөвсгөл нуур руу аялж, жуулчдад өөрсдөө үйлдвэрлэсэн эсвэл импортолсон бэлэг дурсгалын зүйл (сувенир) худалддаг. Нуурын орчим цаа буга бэлчих газар байхгүй тул цаатнууд сүргээ бэлчээх шаардлагын улмаас нуур орчмын зам дээр буухдаа удаан хугацаанд саатдаггүй. Цаатнууд ХНБЦГ-т байнгын эсвэл тогтмол буудаг суурингүй бөгөөд нүүдэллэдэг тогтсон замгүй ба уламжлалт мал аж ахуй эрхэлдэггүй. Төслийн хувьд Цаатнуудад үзүүлэх үр нөлөө байхгүй хэмээн тооцож байгаа хэдий ч эко-жуулчлалын үйл ажиллагааг төлөвлөхдөө үндэстэн ястны соёлын онцлогийг харгалзах болно.

## Оролцогч талуудын харилцаа, оролцоо ба зөвшилцөл

Төслийн төлөвлөлтийн үед	Хөвсгөл нуурыг Монголчууд дээдлэн хайрладаг бөгөөд хэвлэл мэдээллийн хэрэгслүүд тогтмол сурвалжилдаг олны анхаарал татсан бүс нутгийн нэг юм. Төсөлд хамрагдах оролцогч талуудтай харилцах стратегийг боловсруулсан ба түүнд зорилтот харилцагчдыг тодорхойлж, олон нийтийн арга хэмжээ, сургалт семинар зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн оролцох үйл ажиллагааг төлөвлөсөн болно.
Төслийн хэрэгжилтийн үед	Дээрхийн ижил.

## Бизнесийн боломж

Зөвлөх үйлчилгээ	Төслийн хүрээнд 1 олон улсын зөвлөхийг 3 хүн-сараар, 16 үндэсний зөвлөхийг 487 хүн-сараар ажиллуулна. Эдгээр 17 орон тоонд захиргааны 7 орон тоо (ТУН-ийн менежер, ТХН-ийн орон нутгийн зохицуулагч, ня-бо, худалдан авалтын мэргэжилтэн, жолооч) болон 10 техникийн мэргэжилтэн багтсан. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь АХБ-ын Зөвлөх үйлчилгээ авах удирдамж (2013 оны хувилбар болон нэмэлт өөрчлөлтийн хамт)-ийн дагуу зөвлөхүүдийг тус бүрээр нь сонгон шалгаруулна.
------------------	--

Худалдан авалт ТУН нь төсөл хэрэгжүүлэгч байгууллагыг төлөөлөн, худалдан авалтыг хариуцна. ЯБЯС-ийн буцалтгүй тусламжаар санхүүжигдэх аливаа худалдан авалтыг АХБ-ны Худалдан авалтын удирдамж (2015 оны хувилбар болон нэмэлт өөрчлөлтийн хамт) болон Сангийн яамны 2014 оны Худалдан авалтын гарын авлагад заасны дагуу хийж гүйцэтгэнэ. Буцалтгүй тусламжаар санхүүжигдэх аливаа ажил, бараа ба/эсвэл зөвлөх үйлчилгээг сонгох, гүйцэтгэгчдийг гэрээлэхэд АХБ-ын зөвшөөрлийг авна.

АХБ-ын хариуцсан ажилтан	Марк Р. Безайн
АХБ-ны хариуцсан газар	Зүүн Азийн Газар
АХБ-ны хариуцсан хэлтэс	Байгаль орчин, байгалийн баялаг ба хөдөө аж ахуйн хэлтэс, Зүүн Азийн газар
Хэрэгжүүлэгч байгууллага	<b>Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам,</b> Засгийн газрын байр II, Нэгдсэн үндэстний гудамж 5/2, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар 15160, Монгол Улс

### Хуваарь

Үзэл баримтлалыг батлах	2015 оны 5 сарын 8
Урьдчилсан судалгаа	2015 оны 6 сарын 4-21
Менежментийн хяналтын уулзалт	2015 оны 7 сарын 22
Батлагдах	2015 оны 12 сарын 7
Сүүлд хийсэн хяналт	-
ТМТ-г шинэчилсэн	2015 оны 10 сарын 5

Төслийн Мэдээллийн Тайлан (ТМТ)–д төсөл болон хөтөлбөрийн талаарх хураангуй мэдээлэл багтдаг: ТМТ нь одоогоор хэрэгжиж байгаа ажлын тухай байдаг тул тайлангийн анхны хувилбарт зарим мэдээлэл багтаагүй байж болох ба бэлэн болсон үед нь нэмж оруулдаг. Санал болгож байгаа төслийн талаарх мэдээлэл нь урьдчилсан бөгөөд тойм шинж чанартай.

АХБ нь энэхүү Төслийн Мэдээллийн Тайлан (ТМТ)–г хэрэглэгчдэд гагцхүү мэдээллийн чанартай хүргэж байгаа бөгөөд ямарваа нэгэн амлалт, баталгаа өгөхгүй. АХБ нь мэдээллийн агуулгыг чанарын өндөр түвшинд гаргахыг эрмэлзсэн хэдий ч тухайн мэдээллийг “байгаагаар нь” ойлговол зохих бөгөөд арилжааны шаардлагыг хангах, тодорхой зорилгоор ашиглахад нийцэх эсвэл бусдын эрхэд халдахгүй байх гэх мэт ямарваа нэгэн шууд болон шууд бус баталгааг өгөхгүй. Нэн ялангуяа, тайланд агуулагдсан мэдээлэл үнэн зөв бөгөөд бүрэн бүтэн болох талаар ямар нэгэн баталгаа эсвэл мэдэгдэл гаргаагүй болно.